

2025 ОНЫ 07 ДУГААР САРЫН 28-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-07-28

Өндөртөлгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 08 дугаар сарын 05-ны “Мягмар” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6. Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.
- 8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
- 8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
- 8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
- 8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Өвөлжилтийн бэлтгэл хангах тухай” А/934 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, төлөвлөсөн ажлаа эрчимжүүлж ажиллах.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн хангамжийн байгууллагууд
2	Өвөлжилтийн үед хүндрэл гарч болзошгүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, халаалтын зуух, бусад барилга байгууламжийн цахилгаан, дулаан, шугам сүлжээний засварын ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо, судалгааг яаралтай гаргаж, танилцуулах.	НХХ, Боловсролын хэлтэс, ЕБС, СӨББ-ууд, ЭМТ, инженерийн хангамжийн байгууллагууд
3	Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдлыг хангах, авто замын шар тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, анхааруулга, санамж бүхий тэмдгүүдийг 09 дүгээр сарын 01-ний дотор байршуулж, засварлаж дуусгах.	ЦХ-ийн ЗЦХ, НХХ, Боловсролын хэлтэс ЕБС, СӨББ-ууд
4	Авто замын гэрэлтүүлэг болон хяналтын теле камерийн гэмтлийг тухай бүр нь шуурхай засварлаж, замын хөдөлгөөний хэвийн үйл ажиллагааг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах	Цагдаагийн хэлтэс, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
5	Нийтийн эзэмшлийн зам, талбайн халтиргаа, гулгааг арилгах тусгай зориулалтын бодис, элс, давсыг хангалттай нөөцөлж, стандартын дагуу агуулах, сав бэлтгэх.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
6	2024 оны өвөл дулааны шугам нь доголдож халаалтгүй болсон сургууль, цэцэрлэгүүдийн талаарх мэдээллийг боловсруулан танилцуулах.	НХХ, НЕБ-ын 94 дүгээр сургууль, Холбогдох байгууллагууд
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
7	2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд СӨХ-ны үйл ажиллагааг эрчимжүүлэн, орон сууцны байрнуудын дулаалга, орчны хаалганы эвдрэл, гэмтлийг засварлах ажлуудыг гүйцэтгэх.	ТХҮХ, СӨХ-нууд
8	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй нийт байгууллагууд гадна өнгө үзэмжээ сайжруулж, гадна гэрэлтүүлэг, хаягаа засварлах.	ТХҮХ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, нийт байгууллагууд
9	Хог хаягдлаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэд, олон нийтэд бэлтгэн хүргэж буй видео бичлэг, контент, нөлөөллийн ажлуудыг олон нийтэд түгээхэд анхаарч, хамтран ажиллах.	Хэвлэл мэдээллийн ажилтан, Багахангай тохижилт ОНӨААТҮГ, нийт байгууллагууд
10	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн шарилж устгалын ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Нийт байгууллагууд
11	Дүүргийн нутаг дэвсгэр дэх Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд мал бэлчээхгүй байх талаар малчин болон мал бүхий иргэдэд мэдээллийг хүргэх, хариуцлагын арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	ХААТ, Цагдаагийн хэлтэс

12	Улс, нийслэл, дүүргийн татварын орлого бүрдүүлэлтийн мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар бэлтгэн дараагийн Удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнд танилцуулах.	Татварын хэлтэс
13	2025-2026 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд инженерийн хангамжийн байгууллагуудад хийгдэж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудын мэдээллийг бэлтгэн иргэд, олон нийтэд тухай бүр мэдээлэх.	Хэвлэл мэдээллийн ажилтан, Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, инженерийн хангамжийн байгууллагууд
14	Дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан "Сүүдрэвчтэй худалдаа эрхлэх байршил"-ын дагуу 1 дүгээр хорооны 2-р байрны урд байрлан үйл ажиллагаа явуулж буй худалдаа эрхлэгч иргэний "Сүүдрэвч"-ний өнгө үзэмжийг сайжруулах.	ТХҮХ, ЖДҮҮДТ

ТАНИЛЦСАН

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Х.ЦОГЦЭЦЭГ

ХЯНАСАН

ГАДААД ХАРИЛЦАА ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ГЭРЭЛЦОЛМОН

НЭГТГЭСЭН

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР